

## МАНЖИЙН ЭРХШЭЭЛЭЭС ӨМНӨХ ҮЕИЙН ХАЛХЫН СЭЦЭН ХАНГУУДЫН УЛС ТӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Ц.ЦЭРЭНДОРЖ

**Товч агуулга:** Тус өгүүлэлд Халхын Сэцэн хан Шолой тэргүүтэй эхэн үеийн Сэцэн хангуудын улс төр, нийгэм, соёл, дипломатын үйл ажиллагааг судалж, тэдний түүхэнд эзлэх байр суурь, нөлөөг нэгтгэн дүгнэсэн байна. XVII зууны 30-аад оны эхээр Халхын дорнод хэсэгт Сэцэн хан хэмээх нөлөө бүхий эрх мэдэлтэн тодрон гарч, Халхын дотоод улс төр хийгээд гадаад харилцаанд чухал үүрэг гүйцэтгэх болжээ. Ялангуяа хамгийн анхны Сэцэн хан Шолой Монголын сүүлчийн их хаан Лигдэн Хутагт хааныг нас барсны дараа түүний хөвгүүд, хатдыг Халхад залж авчрах, өвөрлөгчдийн зарим аймгийг өөртөө татаж харьяандаа оруулах, Манж Чин улстай эрх тэгш, найрамдалт харилцаа тогтоох, Халхын Түшээт ханы хөвгүүнийг Жибзундамба хутагтаар өргөмжилж, улмаар түүний нөлөөг нийт Халхад тогтоох тал дээр Түшээт ханыг дэмжих зэргээр маш өргөн цар хүрээтэй үйл ажиллагаа явуулж байв. Гэвч Шолойгоос хойшхи Сэцэн хангуудын үйл ажиллагааны цар хүрээ улам бүр буурсаар байсан аж. Хэдийгээр Шолойн дараахь Сэцэн хангуудын үйл ажиллагаа түүнийг гүйцэхгүй, бусдын нөлөөнд их бага хэмжээгээр автах хандлага байсан боловч, Шолойг залгамжлан Сэцэн хан хэмээх цол зүүж, харьцангуй нэгдмэл байдлаа хэвээр хадгалсаар байсан явдал нь хожим Манжийн эрхшээлийн үед Сэцэн хан аймаг хэмээх бие даасан аймаг бий болох үндэс суурь нь болжээ.

**Түлхүүр үг:** *Халх, Шолой, Сэцэн хан, Түшээт хан, Халхын зүүн гар, Манж Чин улс.*

### Оршил

XVI зууны сүүлчээр Монгол улс ерөнхийдөө Ар Халх, Өмнөд Монгол, Ойрад гэсэн 3 хэсэгт хуваагдах болжээ. Эдгээрийн дотроос Ар Халх нь өнөөгийн Монгол улсын гол цөмийг бүрдүүлсэн билээ.

Ар Халх хүчирхэгжсэн үйл явц нь Батмөнх даян хааны 11-р хөвгүүн Гэрсэнз, түүний үр хойчсын идэвхтэй үйл ажиллагаатай холбоотой юм. Батмөнх даян хаан

өөрийн хөвгүүдэд эзэмшил нутаг, хүн амыг хуваан эзэмшүүлэхэд Гэрсэнзэд Ар Халх оногджээ. Түүнийг нас барсны дараа 7 хөвгүүн нь Ар Халхын 13 отгийг өмчлөн захирах болов. Ийнхүү Халхын 7 хошууны үүсэл тавигджээ.<sup>1</sup>

Халхын 7 хошуу нь баруун, зүүн гарт хуваагдаж байлаа. Энэ үеэс Халхын баруун гарыг Ашихай ганцаар захирч, харин зүүн гарыг Онохуй, Амин нар хуваан захирсан боловч, Онохуйн эрх нөлөө аажмаар ихэссэн гэж үздэг. Халхын баруун гарт Гэрсэнзийн ахмад хөвгүүн Ашихай, 2-р хөвгүүн Ноёнтон, 6-р хөвгүүн Далдан, 7-р хөвгүүн Саму нарын өмчийн 4 хошуу, зүүн гарт 3-р хөвгүүн Онохуй, 4-р хөвгүүн Амин, 5-р хөвгүүн Дар нарын эзэмшил багтжээ.

Эдгээрийн дотроос Монголын дорнод хэсгийг Амин, Дар нар захирч байсан боловч Дар үр хүүхэдгүй өнгөрсөн тул түүний эзэмшил нутаг, ард иргэд Амины мэдэлд орсон ажээ. Амины харьяанд түүнд өөрт нь хувь болон ирсэн хороо хүрээ, цоохор 2 отгоос гадна Дарын мэдэлд байсан хөхүйд, хатагин 2 отог, нийт 4 отог орсон байна. Ийнхүү Ар Халхын 13 отгийн 4-ийг захирах болсон нь Амин хийгээд түүний үр хойчис хүчирхэгжихийн үндэс болсон гэлтэй.

Тус өгүүлэлд Манжийн эрхшээлд орохоос өмнөх Халхын Сэцэн хангуудын улс төрийн үйл ажиллагааны талаар товч өгүүлж, тэдний үйл ажиллагаа, бодлого хожим нь Сэцэн хан аймаг байгуулагдахад ямар нөлөө үзүүлснийг тодруулахыг оролдлоо.

### **Анхдугаар Сэцэн хан Шолой**

XVI зууны сүүлчээр Ар Халхын томоохон язгууртнууд “хан” цолтой болсны анхдагч нь Онохуйн ахмад хөвгүүн Абтай агаад түүний дараахан Ашихайн удмын Лайхур хан цолтой болсноор Ар Халхад хан цолт 2 хүн бий болж, үе дамжин хан цол зүүх болов. Харин 1620-оод оны үед хан цолтон дахин нэгээр нэмэгдсэн нь Амины ач Шолой (1577-1652) байлаа. Шолой бол Амины хоёрдугаар хөвгүүн Моору буймагийн хөвгүүн бөгөөд анхандаа Далай жонон, Далай сэцэн жонон хэмээх цолтой байжээ.

Шолойн өвөг дээдэс болох Амин (1536 онд төрсөн), Моору буйма нарын үйл ажиллагааны тухай сурвалжид тодорхой мэдээ үгүй. Моору буйма 1627 онд нас барахад Шолой эцгийнхээ суурийг залгамжилсан гэж судлаачид үздэг ажээ.<sup>2</sup> Моору буйма Хэрлэн голын савд нутаглаж байсан агаад түүний үр хойчис ч Хэрлэн голын саваар төвлөн, Халхын дорнод хэсгийг эзэмшиж байжээ.

<sup>1</sup> Гонгор, Д. *Халх товчоон*. Боть I. Улаанбаатар: 1970, 176.

<sup>2</sup> Гомбосүрэн, Д. *Махасамати гэгээн Сэцэн хан Шолой*, Улаанбаатар: 2007, 19.

Шолой Халхын ноёдын хэлэлцэн баталсан 1614, 1616 оны цаазад Далай сэцэн хунтайж цолтой оролцсоноос хойш түүний улс төрийн үйл ажиллагааны дүр зураг нэлээд тодорхой болж ирдэг. Улмаар Монголын сүүлчийн их хаан Лигдэний хүчлэн барих засаглалыг эсэргүүцсэн Өвөрлөгч (Өмнөд Монгол буюу өнөөгийн Өвөр Монгол)-ийн Авга, Авга нар, Үзэмчин, Хуучид, Сүнид аймгийн зарим ноёд харьяатаа дагуулан Шолойг түшихээр Халхад ирснээр Шолойн хүч ихэд нэмэгджээ. Энэ нь барагцаалбал 1620-оод оны үед болсон үйл явдал гэлтэй. Эдгээр өвөрлөгч ноёд Халхад нутаглах хугацаандаа Лигдэн хааны эсрэг мөчөөрхөн тэмцэх явдал ч гаргаж байжээ. Тухайлбал, Авга аймгийн ноёд 1628 онд Харчин, Түмэд, Ордос зэргийн аймгийн ноёдтой хамт Цахарын цэрэгтэй тулалдсан аж.<sup>3</sup>

1620-оод оны үед эдгээр өвөрлөгч ноёд санаачлан Шолойд “хан” цол өргөснөөр Ар Халхад 3 хан буй болов. Тэгээд Шолойн хуучин цол чимгийг хэрэглэн “Далай сэцэн хан” гэж нэрлэх болжээ. Шолой хан цолтой болсон талаар хожим Түшээт хан Чахундорж Манжийн хаанд айлтгасан бичигтээ: “Далай жонон (*Шолой- Ц.Ц.*)-д Цахар, Авгын оруул олон ирээд хаан цол дуудсанд Сэцэн хаан өөрөө эмээж, манай эцэгт (*Түшээт хан Гомбо- Ц.Ц.*) ‘Оруул ноёд намайг ташиж хаан цол дуудаж байнам. Би өөрөө өдсөн бус бөлгөө. Байтугай гэхүл байя’ хэмээсэнд манай эцэг хаан ‘Би муучлахгүй. Эртний ёсоороо яв’ хэмээж урьдах ёсоороо явуулаад, хаан цолыг ч байлгасангүй. Ямар юманд манай эцэг хааны зарлигаас давалгүй явсан билээ”<sup>4</sup> гэх зэргээр Түшээт хан Сэцэн ханаас илүү эрх мэдэлтэй байсан мэтээр бичиж байв. Түүнчлэн энэ үед Түшээт хан Гомбо (Бас Гомбодорж ч гэдэг) Халхын зүүн гарыг тэргүүлж байсан гэж сурвалжид тэмдэглэсэн боловч<sup>5</sup>, үнэн хэрэгтээ Шолой түүнээс дутахгүй эрх мэдэлтэй байж, зүүн гарыг Гомбодоржийн хамтаар захирч байсан гэлтэй байна.

1630-40-өөд онд Манжийн хаанд илгээсэн захидал бичгүүдэд Сэцэн хан Шолой хамгийн эхэнд нэрээ тавьсан бичиг нэлээд байгаагаас үзэхэд ч Шолойг Түшээт хан захирч байсан гэж үзэхэд өөрийн эрхгүй эргэлзээ төрүүлж байна. Шолой Гомбо (1594 онд төрсөн)-оос насаар ахмад байсан хэдий ч, захидал бичиг бичихдээ нас сүүдрээс илүүтэйгээр зэрэг зиндааг чухалчилдаг байсан нь мэдээж юм.

Ийнхүү Шолой хан цолтой болж, хүч нөлөө нь нэмэгдсэнээр түүний улс

<sup>3</sup> *Зарлигаар тогтоосон гадаад монгол, хотон аймгийн ван гүнгүүдийн илтгэл шастир* (1-44-р дэвтэр), Монгол бичгээс кирилл бичигт буулгаж, тайлбар хийсэн Ц.Цэрэндорж, Л.Эрдэнэболд, Н.Ганбат, Д.Баржав, Улаанбаатар: 2007, 241. Авга аймгийн шастирын хураангуй.

<sup>4</sup> *Дайчин гүрний дотоод яамны монгол бичгийн гэрийн данс*. 6-р боть, Улаанбаатар: 2010.

<sup>5</sup> *Зарлигаар тогтоосон гадаад монгол, хотон аймгийн ван гүнгүүдийн илтгэл шастир* (45-78-р дэвтэр), Монгол бичгээс кирилл бичигт буулгаж, тайлбар хийсэн Ц.Цэрэндорж, Л.Эрдэнэболд, Н.Ганбат, Д.Баржав, Улаанбаатар: 2009, 6. Халхын Түшээт хан аймгийн шастирын хураангуй.

төрийн үйл ажиллагаа нэлээд эрчимжиж эхэлсэн юм. 1630-аад оны эхээр Шолой Түвэдийн 5-р Далай ламаас “Гэгээн” хэмээх цолыг хүртсэнээр<sup>6</sup> “Гэгээн сэцэн хан”, “Гэгээн далай сэцэн хан” гэгдэх болжээ. Бас Шолойг “Махасамади хаан” хэмээн нэрлэдэг байсан агаад чухам хэдийнээс ийн нэрлэх болсон талаар тодорхой мэдээ үгүй. Ямартай ч “Махасамади хаан” буюу “Олноо өргөгдсөн хаан” хэмээх эрхэмсэг цол нь түүний санаархлыг харуулж байна гэлтэй. Махасамади нь Энэтхэгийн хаадын анхдагч буюу бурханы шашны түүх бичлэгийн ёсоор дэлхийн хаадын язгуур үндэс болсон их хааны цол. Өөрөөр хэлбэл, Шолой Халхын ноёдын дотор тэргүүлэх байр суурь эзлэхийг оролдохдоо өөрийн цолондоо хүртэл анхаарал хандуулж байсан гэж үзэж болно.

1630-аад оны дунд үед Шолой улс төрийн идэвхитэй үйл ажиллагаа явуулах болов. Тэрээр газар нутаг ойрын хувиар өвөрлөгч ноёдыг биедээ татахын хамтаар, Лигдэн хааныг нас барсны дараа Монголын их хааны ширээ залгамжлагчийн асуудалтай холбогдуулан Хожуу Алтан улстай харилцаж эхэлжээ.

1534 оны зун Лигдэн хан өнөөгийн Хятадын Ганьсу мужийн нутагт нас барсанд түүний хатан Сутай тайху, Зэлэм дархан зэрэг тэргүүлэх ноёд Соном тайж хиаг Шолойд илгээж Лигдэн хааныг нас барсныг мэдэгдэхийн хамт, зүүн тийш буцаж нүүсээр Өвөр Монголын Их зуу аймгийн нутагт хүрч, түр саатан хүлээж байжээ. Ийнхүү Монголын их хааны хатан Сэцэн хан Шолойд элч зарсан явдлыг Шолойн байр суурь өндөр байсан гэдгээс гадна, Сутай тайху хатан Шолойн хатантай төрөл садны холбоотой байснаар тайлбарлах нь зүйд нийцнэ.

Шолой ийнхүү Сутай тайху нарын захидлыг хүлээж аваад, манж нараас өрсөж, Лигдэн хааны ахмад хөвгүүн Эрх хонгор Эжэй, Сутай тайху нарыг Халхад залан ирүүлж их хааны гал голомтыг сахин хамгаалах асуудлыг зөвлөлджээ. Тэгээд 1635 оны зун Лигдэн хааны хатад, хөвгүүн, харьяат ардыг Халхын нутагт урин авчрах тухай зарлигийн бичгийг Лигдэний хатан, хөвгүүнд илгээжээ.

Тэрхүү зарлигт: “Олноо өргөгдсөн Мах-а-Самади Сэцэн хааны зарлиг. Тайху, эрх хүүхэн, Зэлмэ дархан ноён тэргүүлэн хэдэн зайсангуудад бичиг өгөв... Бид тусдаа үг өш хясаагүй билээ. Хаан дээд төрөлдөө өөд болж та бүгдийг айсуй гэхийг сонсож, амурай хайгуул болгож байлаа. Хаанд төрөл билээ. Харцастанд эзэн билээ. Саадгүй ирэлтэй байнам. Цамц дээлээ гэхэд Тайху мань хатанд охин дүү билээ. Бишэд эчим гэхэд төрөөр ч, төрснөөр ч шадар минь энэ билээ. Бас бас дотроо эргүүлж мэд, мэд”<sup>7</sup> гэжээ.

<sup>6</sup> Нацагдорж, Ш. *Халхын түүх*, Улаанбаатар: 1963, 35.

<sup>7</sup> Ли Баовэнь, Намка. “XVII зууны эхэнд холбогдох 43 хувь монгол бичиг”, *Өвөр Монголын*

Түүний зэрэгцээ Сэцэн хан Шолой тэргүүлэн, Түшээт хан, Үзэмчин аймгийн Сэцэн жонон зэрэг ноёдын хамтаар Манжийн хаанд бичиг илгээн Лигдэн хаан нас барж, Монголын хааны ширээ эзгүйрсэн явдлын талаар байр сууриа илэрхийлжээ. Тэрхүү бичигт “...*Бичиг барихын учир: Хан хүмүүнд хас их төр, хамагт сонсдох сайн алдар нэр хэрэгтэйн тулд, хамгаас төр шажныг мандуулах нэрийг эрэлдье. Зургаан түмний эзэн биднийг жолоодон эс чадав. Тэр эс чадавч хан төрөлт бидний өөргүйн тулд хас их төрийг хадгалж суунам бид. Энэ их төрийг санахул нь нааш цааш элчээ тасралгүй мэнд асуулцаж явъя. Ийн хийж явахул эрдэнэт хүний төрөл олж эрх хүчит хан болон төрсний гавъяа бидний(= маань) тэр ажааму гэж айлтганам*”<sup>8</sup> гэжээ.

Үүнээс үзэхэд, Шолой тэргүүтэй Халхын ноёд хэдийгээр Монголын их хаан Лигдэн нас барсан боловч, Ар Халх тусгаар тогтнолоо хадгалахын хамт, Манжтай хөрш зэргэлдээ улсын ёсоор, эрх тэгш харилцах бодлого баримталж байсан нь тодорхой байна.

Энэхүү бичгийн эхэнд Сэцэн хан Шолойн нэр бичигдсэнээс үзэхэд, “Лигдэн хаан нас барсны дараа Халх-Манжийн харилцаанд хамгийн чухал үүрэг гүйцэтгэж чадах нэр нөлөөтэй хүн байсан нь тодорхой байна. Үүнд, Сэцэн хан Шолойн угсаа гарал, эрх хүчин чадал, эзэмшил газар нутгийн байрлал, Өвөр Монгол Халхын харилцаанд гүйцэтгэж ирсэн үүрэг, өвөрлөгч нарын зарим нь түүнийг түшин амьдарч байсан зэрэг нь нөлөөлжээ.”<sup>9</sup>

Гэвч Халхын ноёдоос өрсөж, Манжийн хаан Эрх хонгор Эжэйг харьяат ардын нь хамт хураан авснаар Лигдэн хааны залгамжлагчийг Халхад авчрах санаархал бүтэлгүйтлээр төгсөв. Тиймээс Шолой 1636 оны 1-р сарын 14-нд өөрийг нь түшин суусан Үзэмчиний Сэцэн жонон, Сүнидийн Баатар жонон, Хуучидын Галдан түшээт, Авгын Засагт жонон нарын хамт Манжийн хаанд элч илгээжээ. Тэдний илгээсэн бичигт “энхжүүлэх төрийг тэнд Сэцэн хаан (Манжийн Хунтайж-Ц.Ц.) мэд” хэмээн Өмнөд Монгол Манжид эзлэгдсэн явдлыг хүлээн зөвшөөрсөн боловч, “нааш цааш тасралтгүй мэнд юугаан асуулцаж, төрийн гадаах шашны наран болж эе нэр хоёрыг эвдрэлгүй сахилдъя”<sup>10</sup> хэмээн Манжийн хааныг бүх Монголын хаан гэж хүлээн зөвшөөрөхөөс урьдын адил татгалзан, хөрш улсын ёсоор эрх тэгш

---

нийгмийн шинжлэх ухаан, 1993, №2, 100-101.

<sup>8</sup> Ли Баовэнь, Намка. “XVII зууны эхэнд холбогдох 43 хувь монгол бичиг”, *Өвөр Монголын нийгмийн шинжлэх ухаан*, 1993, №2, 99-100.

<sup>9</sup> *Монгол улсын түүх*, Дөтгөөр боть, Улаанбаатар: Адмон, 2003, 72.

<sup>10</sup> Ли Баовэнь, Намка. “XVII зууны эхэнд холбогдох 43 хувь монгол бичиг”, *Өвөр Монголын нийгмийн шинжлэх ухаан*, 1993, №2, 1993, №2, 101-р тал.

харилцъя гэдэг байр сууриа хадгалсаар байжээ.

Үүнээс хойш 1640 он хүртэл Сэцэн хан Манжийн хаантай элч солилцож, бэлэг сэлт хүргэх зэргээр найрсгаар харилцах бодлого явуулав. Харин Манжийн тал “Халхын ноёдоос хөрш улсын ёсоор Манжтай харилцан, элч зарсан явдлыг санаатайгаар мушгиж, Манж улсын хараат болсны гэрч баталгаа болгон урвуулан ашиглахыг оролдох болжээ.”<sup>11</sup> Гэвч Сэцэн хан тэргүүтэй Халхын хан ноёд үүнийг хүлээн зөвшөөрөхгүй, тусгаар байдлаа сахин хамгаалах бодлогыг тууштай баримталсаар байсан билээ.

Манжийн түрэмгий бодлогын хариуд, “Халхын ноёд дотооддоо эе эвээ бэхжүүлэн, нийт монголчуудыг оюун санаа, үзэл суртлын талаар нэгтгэх, Өвөр Монголын зарим ноёдыг өөртөө эргүүлэн татах, Дөрвөн Ойрадтай хүчээ нэгтгэн хамтын хүчээр Манжийн түрэмгийллийг сэргийлэх арга замыг сүвэгчлэх”<sup>12</sup> болжээ. Энэхүү үйлсэд Сэцэн хан Шолой идэвхтэй оролцсон юм.

1639 онд Халхын зүүн гарын хан ноёд Ширээт цагаан нуур хэмээх газар чуулган хийж, Түшээт хан Гомбодоржийн хөвгүүн Занабазарыг Халхын шарын шашны тэргүүнээр өргөмжлөв. “Өндөр гэгээний намтар оршвой” хэмээх монгол сурвалжид өгүүлснээр Сэцэн хан Шолой Занабазарыг эхийн хэвлийд байхаас нь эхлэн Халхыг удирдан тэргүүлэх бусдаас хэтийдсэн сайн хөвгүүн төрөх нь хэмээн мэдэж, төрсөн хойно нь Занабазарт өөрийн “гэгээн” хэмээх цолоо өргөсөн<sup>13</sup> гэлцдэг. Мэдээж хэрэг, Түшээт ханыхан өөрсдөө Занабазарыг магтах нь зохисгүй учир тухайн үед Халхын зүүн гарт их нөлөөтэй байсан Сэцэн хан Шолойн үг, үйлдлээр өөрсдийн санааг төлөөлүүлэн гаргасан тал байхыг үгүйсгэх аргагүй. Гэвч ямартай ч энэ нь Занабазарыг Жибзундамба хутагтын хойт дүрээр тодруулахад Шолой Түшээт хантай адил байр суурьтай байж, түүнийг идэвхтэй дэмжиж байсныг харуулах баримт юм. XVII зууны дунд үед Халхын томоохон язгууртнууд бараг бүгд өөрийн хөвгүүнийг бурханы шашны хутагтаар тодруулж байсан атал гагцхүү Сэцэн ханы угсааныхны дунд хутагт хувилгаад үзэгдэхгүй байгаа нь Занабазарыг дэмжин, Халхыг шашны тугийн доор нэгтгэх бодлогыг Сэцэн хангууд тууштай дэмжиж байсны нотолгоо гэлтэй.

Түүнчлэн Халх, Ойрад хоёр эе эвээ нэгтгэх зорилгоор 1640 онд Тарвагатайн Улаан бураад Ойрад, Халхын чуулган хуралдуулж, “Их цааз”-ыг батлахад Сэцэн ханы угсааныхан оролцжээ.

---

<sup>11</sup> *Монгол улсын түүх*, Дөтгөөр боть, Улаанбаатар: Адмон, 2003, 75.

<sup>12</sup> *Монгол улсын түүх*, Дөтгөөр боть, Улаанбаатар: Адмон, 2003, 75.

<sup>13</sup> *Өндөр гэгээний намтрууд оршивой*, Улаанбаатар: ШУА, 1995, 8-9.

Халхын хан ноёд ийнхүү эе эвээ бэхжүүлэхийн хамтаар, Өмнөд Монголын ноёдыг аргадан, өөртөө татах бодлого явуулав. Энэ хэргийг Сэцэн хан Шолой гардан зохион байгуулсан юм. 1620-оод онд Шолойг түшихээр Халх нутагт нүүж ирсэн Авга, Авганар, Үзэмчин, Сүнид, Хуучид зэрэг аймгуудын ихэнх нь Шолойг Манжтай харилцаж эхэлснээс хойш буюу 1635 оноос хойш Манжид дагаар орсноор Шолойн хүч нэлээд сулрах байдалтай болоод байжээ. Тухайлбал: Үзэмчин 1637, Сүнид 1639, Авга аймгийн зарим хэсэг 1639, Хуучидын зарим хэсэг 1637 онд тус тус Манжид дагаар оржээ. Тиймээс Шолой эдгээр аймгуудыг дахин өөртөө татах бодлого явуулсны тод илрэл нь Сүнидийн Тэнгис вангийн бослого юм. Тэнгис угтаа Шолойг түшиж Халхын газар нутаглаж байгаад, 1639 онд Манжид дагаар орсон хүн юм. Гэвч тун удалгүй, 1646 онд Тэнгис албат ардаа дагуулан Халхын нутаг руу нүүжээ. Үүний цаад эзэн, өдөөгч нь Шолой байсан хэмээн манжийн албан сурвалжид шууд нэр цохсон байдаг. Энэ талаар “Илтгэл шастир”-т: “Еээр засагчийн гуравдугаар он (1646) Шолой Сүнид аймгийн тэргүүлсэн хүн Тэнгисийг аргадан урвуулж, түүний хөвгүүн Бумба таныг гурван түмэн цэрэг авч өмөглөөр илгээснийг их цэрэг байлдаж дарвай. ... Тавдугаар он (1648) Тэнгис дагасугай хэмээн гуйвай. Шолой хүн зарж зуун тэмээ, мянган морь барьж ял хүлээн авч мөргөөр ирсэнд зарлигаар түүний хөвгүүд дүү нарыг бараалхуулаар илгээтүгэй хэмээн тушаавай”<sup>14</sup> гэх зэргээр тэмдэглэжээ.

1646 оны зун Манжийн их цэрэг Тэнгис нарыг нэхсээр Туул гол орчимд гүйцэж, ихэд дараад, Тэнгист туслахаар ирсэн Түшээт ханы 2 түмэн цэрэг, Сэцэн ханы 4 хүүгийн удирдсан Авганар, Барга, Хатагин, Урианхан 4 аймгийн 3 түмэн цэргийг дараалан ялснаар Тэнгисийн хэрэг явдал бүтэлгүйтлээр төгссөн билээ. Манжийн цэрэг Тэнгис нарыг баривчлаад зогсохгүй, чадвал Сэцэн хан Шолойг дайлан дагуулах зорилготой байсан боловч, Шолой, Тэнгис нар Сэлэнгэ мөрөн тийш зайлан нутагласан тул манж нар зорьсноо биелүүлж чадсангүй. Манжийн цэрэг хэдийгээр Халхын цэргийг ухруулсан боловч, Халх нутгийн гүнд үргэлжлүүлэн байлдааны ажиллагаа явуулах нь аюултай байсан учир удалгүй цэргээ эргүүлэн татжээ. Халхын зүүн гарын цэрэг ашиг алдсаныг сонсоод, Засагт хан Субади их цэрэг авч туслахаар ирэхээс болгоомжилсон байж ч мэднэ.

Гэвч 1648 онд Тэнгис Манжид буун өгч, Шолой ч бас элч зарж, Тэнгист тусалсан “гэмээ хүлээсэн” ажээ. Манж нар үүгээр шалтаглан Сэцэн хан нарыг

<sup>14</sup> *Зарлигаар тогтоосон гадаад монгол, хотон аймгийн ван гүнгүүдийн илтгэл шастир* (45-78-р дэвтэр), Монгол бичгээс кирилл бичигт буулгаж, тайлбар хийсэн Ц.Цэрэндорж, Л.Эрдэнэболд, Н.Ганбат, Д.Баржав, Улаанбаатар: 2009, Халхын Сэцэн хан аймгийн шастирын хураангуй.

шахамдуулж, эрхэндээ оруулахыг оролдсон боловч бүтсэнгүй.

Нөгөө талаар, Сэцэн хан Шолойн гадаад бодлогын нэг хэсэг нь Оростой харилцах явдал байлаа. XVII зууны эхээр Хаант Орос улс дорно тийш нутгаа тэлсний улмаас халхчууд Оростой нүүр тулгаран, харилцах болов. Оросууд дорно тийш давшсаар 1640-өөд оны үед Сэцэн ханы эзэмшил нутагт тулж иржээ. 1646 онд анх Оросын элч К.И.Москвитин “мөнгөний хүдэр хайх” нэрийн доор, Шолойн өргөөнд хүрэлцэн ирсэн боловч, Сэцэн хан түүнийг хүлээн аваагүй ажээ. Үүний дараа 1647 онд Оросын элч Я.Кулаков Шолойн өргөөнд ирж түүнтэй уулзжээ. Харин 1648 онд Оросын элч И.Похабов, Я.Кулаков нар Шолойд ирж бараалхахад тэрээр “манай нутагт мөнгөний орд байдаггүй, Хятадад байдаг, тэнд хүрэхэд сарын газар явна” хэмээгээд, түүний Хятад руу нэвтрэх хүсэлтийг зөвшөөрөөгүй байна.<sup>15</sup> Тэгээд Шолой Похабов нарын хамт өөрийн элч Садикийг Оросын хаанд илгээсэн бөгөөд тэд 1649 оны эхээр Москвад хүрч, Оросын хаантай уулзжээ. Тэрхүү элч оросууд Халхын нутагт зэвсэгт хүмүүс илгээж байгаагаа зогсоох, тус тусынхаа нутагт эв найртай амьдран суух Сэцэн ханы хүсэлтийг уламжилжээ.<sup>16</sup>

Сэцэн ханы элчийг Москвагаас буцахад тэднийг дагалдуулан Е.Заболоцкий тэргүүтэй хүмүүсийг албан ёсны элчээр томилжээ. Тэрхүү элчийн зорилго нь Сэцэн ханыг Орост дагаар оруулах явдал байсан хэдий ч, элч нар 1650 оны эцсээр Сэлэнгэ мөрний орчимд монголчуудын довтолгоонд өртөн Заболоцкий нарын 8 хүн алагдаж, хэлмэрч П.Семенов тэргүүтэй цөөн хүн амьд үлджээ. Тэд цааш явсаар Шолойн өргөөг Туул голд байхад нь ирсэн боловч, Шолой нас барсан байсан тул түүний хатан Ахай тайхутай уулзжээ. Ахай тайху Орост дагаар орох талаар ямар ч яриа хэлэлцээр хийхгүйг мэдэгдэж, харин Оросын хаантай эв найртай харилцах, элч солилцох хүсэлтэйгээ илэрхийлжээ.<sup>17</sup> Гэвч үнэн хэрэгтээ энэ үед Шолой нас бараагүй байсан<sup>18</sup> гэж судлаачид үздэг бөгөөд Оросын элчид өгсөн дээрх хариулт нь Шолойн заавар зөвлөгөө байсан гэж үзэх нь зүйтэй. Ийнхүү Шолой Оросын хүч түрэмгийлэх бодлогыг эсэргүүцэж, тусгаар тогтнолоо хамгаалах байр суурийг тууштай баримталж байв. Шолойгоос хойш Орос улс Сэцэн хангуудтай элч зарж харилцаагүй ажээ.

Шолой хэдийд нас барсан тухай тодорхой баримт байхгүй ч 1652 оны үед нас барсан гэдэг дээр ихэнх судлаач санал нэгддэг. Халхын анхны Сэцэн хан Шолойн үйл ажиллагааг ерөнхийд нь дүгнэн хэлбэл, тэрээр Гэрсэнзээс өвлөгдөж ирсэн

<sup>15</sup> *Материалы по истории Русско-Монгольских отношений*. Москва: 1974, 330.

<sup>16</sup> *Монгол улсын түүх*, Гутгаар боть, Улаанбаатар: Адмон 2003, 154.

<sup>17</sup> Шастина, Н.П. *Русско-Монгольские посольские отношения XVII века*. Москва: 1958, 76.

<sup>18</sup> Гомбосүрэн, Д. *Махасамади гэгээн Сэцэн хан Шолой*. Улаанбаатар: 2007, 35.

Халхын 7 том эзэмшлийн 2-ыг нь нэгтгэн захирсны дээр, Өмнөд Монголын зарим аймаг түүнд түшсэнээр ихээхэн хүчирхэг болж, XVII зууны 30-50-аад оны үед Халхын улс төрийн амьдралд томоохон байр суурь эзлэх болжээ. Ялангуяа Халхын тусгаар тогтнолыг бэхжүүлэх, монгол төрийн гал голомтыг сахин хамгаалах тал дээр нэлээд идэвхтэй үйл ажиллагаа явуулсан юм. Тухайлбал, Лигдэн хааныг нас барсны дараа түүний залгамжлагчийг Халхад залж ирүүлэн Монголын төрийн гал голомтыг залгамжлах оролдлогыг хийсэн билээ. Түүнчлэн өөр хоорондын эв нэгдлээ бэхжүүлэх замаар тусгаар тогтнолоо сахин хамгаалах бодлогыг тууштай дэмжиж, ялангуяа энэ талаар Түшээт хан Гомбо[дорж]той гар нийлэн ажиллаж байлаа. Түшээт хан ч Сэцэн хан Шолойг ихэд хүндэтгэж, дэмжиж байсан нь түүнтэй нэр хамтатган Манжийн хаанд захидал бичиг илгээсэн, ялангуяа Сүнид аймгийн Тэнгисийг өмгөөлж цэрэг гарган байлдсан явдлаас тодорхой харагддаг.

Тэгвэл тухайн үед өөрийгөө Халхын хамгийн гол эрх мэдэлтэн хэмээн үзэж, Манжтай ширүүн тэмцэл явуулж байсан Засагт хан Субади Шолойд хэрхэн хандаж байсан бэ гэдэг асуулт гарч ирнэ. Субади 1646 онд болсон Тэнгисийн хэрэг явдалтай холбоотойгоор Манжийн хаанд бичсэн захидалдаа Шолойг Сэцэн хан гэлгүй, харин Далай жонон хэмээн нэрлэснээс үзэхэд ямартай ч Субади Шолойг өөртэй нь эн тэнцүү хан цолтой болсонд төдий л дуртай байгаагүй бололтой.

Шолой газар нутгийн ойр зэргэлдээ байдлыг ашиглан Манжтай анх харилцаа тогтооход гол үүрэг гүйцэтгэжээ. Мөн Орос улсын зүгээс явуулсан газар нутгийн түрэлтийн эсрэг баттай зогсож, өчүүхэн ч буулт хийгээгүй юм. Түүний эдгээр үйл ажиллагаа, идэвхтэй байр суурь, нэр хүнд нь хожим Сэцэн хан аймаг байгуулагдах баттай үндэс суурийг тавьсан билээ.

### **Сэцэн хан Бабу**

Шолойг нас барсны дараа орыг нь залгамжлах асуудлаар түүний хөвгүүдийн дунд маргаан тэмцэл өрнөв. Шолойг таалал төгсөх үед түүний 3 том хөвгүүн нь хэдүйн нас барсан байсан учир 4-р хөвгүүн Бабу хамгийн ахмад нь болоод байв. Сэцэн ханыг залгамжлуулах асуудлыг хэлэлцэхээр Халхын зүүн гарын ноёдын чуулган болсон агаад уг чуулганд хан ширээг залгамжилбал зохих Шолойн ахмад хөвгүүн Мачари илдэнгийн хөвгүүн Радна мэргэн хунтайж оролцоогүй учир Бабу Сэцэн ханыг залгамжилжээ. Бабуг хан ширээ залгамжлахад Түшээт ханыхны дэмжлэг гол үүрэг гүйцэтгэсэн ажээ. Сурвалжид Бабу 1655 онд Сэцэн хан залгамжилсан гэснээс үзэхэд, хан ширээ залгамжлах үйл явц нэлээд ээдрээтэй нөхцөлд явагдсан нь тодорхой байна. Өөрөөр хэлбэл, Шолойг нас барснаас хойш

3 жилийн дотор түүнийг залгамжлагчийг товлож чадахгүй байсан ажээ.

үйл ажиллагааны талаар сурвалжид тодорхой мэдээ үгүй. Ямартай ч Халхын төр шашны хэрэгт чадлын хэрээр зүтгэж, Манж Чин улстай эв найртай явах бодлого баримталж байсан ажээ. Бабо 30 шахам жил Сэцэн ханы сууринд суугаад, 1683 оны үед нас баржээ. Тэр үед Халхын улс төрийн байдал нэн эгзэгтэй болоод байв. 1650-аад оны сүүлчээс Халхын баруун гарын самуун эхэлж, түүнээс улбаалан үүдсэн Засагт хан, Түшээт хан нарын зөрчил ид өрнөж байлаа. Энэ үед Бабу ямар байр суурь баримталж байсныг харуулах тодорхой мэдээ үгүй хэдий ч, Халхын зүүн гарын томоохон эрх мэдэлтний хувиар ерөнхийдөө Түшээт ханыг дэмжих байсан гэж үзэх нь зүйтэй болов уу.

### Сэцэн хан Норов

1683 оны үед Бабуг нас барсны дараа түүний 3-р хөвгүүн Норов залгамжлав. Тэр цагт түүний 2 ах нь хэдүйн нас барсан байсан тул ахмадын хувиар Норов Сэцэн ханыг залгамжилжээ. Норов цөөхөн жил хан суусан учир түүний талаар мэдээ хомсхон. Зарим судлаачийн бичсэнээр, Норов бүр эцэг Бабуг амьд байхад ах дүүгийнхээ албат иргэдийг булааж, эцгийнхээ үгэнд орохгүй байсан тул тэрээр хан суухдаа олны дэмжлэгийг төдий л хүлээж чадсангүй. Гагцхүү Жибзундамба хутагт, Түшээт хан тэргүүтэй зүүн гарын цөөн ноёны дэмжлэгтэйгээр хан суусан ажээ.<sup>19</sup> Норов 1686 онд Халхын ноёдыг эвлэрүүлэх зорилготой зохион байгуулагдсан Хүрэн бэлчирийн чуулганд оролцсон мэтээр сурвалжид<sup>20</sup> тэмдэглэсэн боловч, үнэндээ түүний ахмад хөвгүүн Илдэн равдан оролцсон<sup>21</sup> бололтой.

1867 онд Норов Түшээт хан Чахундоржтой хамт Манж Чин улсаас эрхэм цол өргөхийг гуйж илэрхийлэн айлтгах бичиг айлтгаж байснаас<sup>22</sup> үзэхэд тэрээр Түшээт ханы үйл ажиллагааг дэмжиж, гар нийлэн ажиллаж байсан нь тодорхой. Норов 1687 онд нас барав.

<sup>19</sup> Боржигидай Оюунбилиг, Сэцэн ханы ор залгамжлагч нь өөрчлөгдсөн тухай. // *Хятад дахь монгол судлал*. II. 2013, 122.

<sup>20</sup> “Илтгэл шастир”-ын “Хорин тавдугаар (1686) он түүний нэгэн төрлийн Түшээт хан Чахундорж, Засагт хан Цэнгүн лүгээ дайн өдсөний учирт зарлигаар Норовт тушааж жолоодож сайнаар нийлүүлбэй” гэсэн мэдээнд үндэслэн Хүрэн бэлчирийн чуулганд Норовыг оролцсон хэмээн үздэг.

<sup>21</sup> *Дайчин гүрний дотоод яамны монгол бичгийн гэрийн данс*. 7-р боть. Улаанбаатар: Соёмбо принтинг. Хүрэн бэлчирийн чуулганы дараа тус чуулганы шийдвэрийг баталгаажуулж тамга дарсан томоохон ноёдын дотор “хоёр хаан (Засагт хан, Түшээт хан)”-ы хамт “Сэцэн ханы хөвгүүн Равдан илдэн тайж” гэсэн нэр гарахаас бус, Сэцэн хан Норовын тухай дурдахгүй байна.

<sup>22</sup> *Зарлигаар тогтоосон гадаад монгол, хотон аймгийн ван гүнзүүдийн илтгэл шастир* (45-78-р дэвтэр), Монгол бичгээс кирилл бичигт буулгаж, тайлбар хийсэн Ц.Цэрэндорж, Л.Эрдэнэболд, Н.Ганбат, Д.Баржав. Улаанбаатар: 2009. Сэцэн хан аймгийн шастирын хураангуй

### Сэцэн хан Илдэн равдан

1687 оны хавар Сэцэн хан Норов нас барсны дараа, Манжийн Энх амгалан хаан Халхын Засагт хан, Түшээт хан, Жибзундамба хутагт нарт хандан, даруй зөвлөлдөж, Норовын ахмад хөвгүүн Илдэн равдангаар хан ширээг залгамжлуул гэсэн зарлиг буулгажээ. Гэвч Жибзундамба хутагт тэргүүтэй Халхын хан ноёд Манжийн хааны дур мэдэн гаргасан энэ шийдвэрийг эсэргүүцэж, өөр хүмүүсийг Сэцэн ханаар өргөмжлүүлэхээр нэрийг нь дэвшүүлэв. Үүнийхээ шалтгааныг тайлбарлахдаа, Илдэн равдан бол эцгийгээ амьд сэрүүн цагт ч зүй бус үйлдэл олонтаа хийсэн, түүнээс гадна ч өөр шалтгаан бий тул түүнийг Сэцэн хан болгох нь зохимжгүй хэмээсэн ажээ. Гэсэн хэдий ч үнэндээ энэ нь шалтаг төдий байсан агаад жинхэнэ санаа нь Халхын хан ноёд Сэцэн ханы залгамжлагчийг Манжийн хаан шууд нэр заан томилсныг эсэргүүцэхэд оршиж байсан<sup>23</sup> гэж зарим судлаач үзжээ.

Гэвч Халхын хан ноёдын эсэргүүцэл үр дүнд хүрэлгүй, Илдэн равдан Сэцэн ханы сууринд суужээ. Тэрээр хан ширээнд хэдхэн сар суугаад, 1688 оны хавар нас баржээ. Тэрээр маш богино хугацаанд хан суусан учир улс төрийн дорвитой үйл ажиллагаа явуулж амжаагүй байна. Түүний үйл ажиллагаатай холбоотой цөөн мэдээ баримт үлдэж хоцорчээ. Тэрээр хан суусныхаа дараа Манжийн хаанд бараалхаж чадахгүй шалтгаанаа “Баруун этгээдийн Өөлд, хойт этгээдийн Орос, зүүн этгээдээс мөнхүү Орос хөөр шог болж байхын тулд”<sup>24</sup> хэмээн тайлбарласнаас үзэхэд, улс орны аюулгүй байдлын асуудалд анхаарал хандуулж байжээ гэж үзэж болно. Гэвч эл хэрэгт өмнөх Сэцэн хангуудын адилаар Түшээт хантай гар нийлэн ажиллаагүй бололтой. Энэ нь түүний сууринд суусан хугацаа асар богино байснаас гадна түүнийг хан суухыг Жибзундамба хутагт тэргүүтэй Түшээт ханы ноёд эсэргүүцэж байсантай холбоотой биз ээ. Түүнчлэн Ойрадын Галдан бошгот 1688 оны хавар Халхыг довтлоход Сэцэн ханы ноёд Түшээт ханыханд тусламж үзүүлэлгүй, шууд Манжийн зүг дүрвэн зайлсан шалтгааныг Илдэн равдан нас барж, нэгдсэн удирдлагагүй болсонтой холбон тайлбарладаг хэдий ч, Түшээт ханд итгэх итгэл буурсан явдалтай тодорхой хэмжээгээр холбон үзэх боломжийг ч бас үгүйсгэх аргагүй.

<sup>23</sup> Боржигидай Оюунбилиг, “Сэцэн ханы ор залгамжлагч нь өөрчлөгдсөн тухай” // *Хятад дахь монгол судлал*, II, 2013, 126.

<sup>24</sup> *Дайчин гүрний дотоод яамны монгол бичгийн гэрийн данс*, 6-р боть, Улаанбаатар: Соёмбо принтинг 2010.

## Төгсгөл

XVII зууны 30-аад оны эхээр Халхын дорнод хэсэгт Сэцэн хан хэмээх нөлөө бүхий эрх мэдэлтэн тодрон гарч, Халхын дотоод улс төр хийгээд гадаад харилцаанд чухал үүрэг гүйцэтгэх болсон юм. Ялангуяа хамгийн анхны Сэцэн хан Шолойн улс төрийн үйл ажиллагааны цар хүрээ, идэвхи санаачилга өөрийн залгамжлагч нараас онцгой ялгарч, Халхын улс төрийн түүхэнд гүн ул мөр үлдээсэн билээ.

Гэвч Шолойгоос хойшхи Сэцэн хангуудын үйл ажиллагааны далайц, цар хүрээ улам бүр буурсаар байжээ. Үүнийг хэд хэдэн хүчин зүйлээр тайлбарлаж болох мэт.

Хамгийн гол шалтгаан нь Түшээт хан Чахундоржийн эрх мэдэл өссөн явдал хэмээн үзэж байна. Түшээт хан Гомбодорж өөрийн хөвгүүн Занабазарыг Жибзундамба хутагтаар тодруулснаар бурханы шашныг улс төрийн хэрэгт амжилттай ашиглан, эрх мэдлээ аажмаар нэмэгдүүлснээс гадна, Түшээт хан Чахундорж 1650-аад оны сүүлчээр өрнөсөн Халхын баруун гарын самуунд хутгалдан оролцож, албат иргэдээ нэмэгдүүлсэн зэрэг нь Түшээт ханыг нэлээд хүчирхэг болгосон гэлтэй. Гэтэл энэ хооронд Сэцэн хангуудын хүч нөлөө харьцангуй суларч, харьяат ард иргэдээ булаацалдах зэрэг дотоод зөрчил гарч эхэлжээ.

Түүнчлэн Түшээт хан, Жибзундамба хутагт тэргүүтэй ноёд чуулган нийлж Сэцэн ханыг сонгодог болсон, ялангуяа Шолойн ахмад хөвгүүний угсааг бус, хан ширээ залгамжлах учиргүй 4-р хөвгүүнийг Сэцэн хан болгосноор үе үеийн Сэцэн хангуудыг өөрийн нөлөөнд оруулах эхлэл тавигдсан гэлтэй байна. Сэцэн ханы залгамжлагчийг ийм байдлаар тогтоох болсон нь Сэцэн ханыг өөрсдийн гар доорхи этгээд болгон хувиргаад зогсохгүй, Сэцэн ханы угсааны ноёдын дунд зөрчил маргаан үүсэх, эе эвдрэх эх үндсийг тавьсан гэлтэй байна.

Мөн Сэцэн ханы хүч чадлыг нэмэгдүүлж байсан өвөрлөгч аймгууд түүнээс салж, Манжид дагаар орох болсон нь түүний хүчийг сулруулжээ. 1651 онд Авга аймгийн зарим хэсэг, 1651 онд Хуучид аймгийн үлдсэн хэсэг, 1665-1666 онд Авганар аймаг тус тус Манжид дагаар орсон нь Сэцэн ханы нэр хүнд буурах, хүч нөлөө нь сулрахад нэрмээс болсон нь дамжиггүй.

Халхын томоохон хан ноёд бараг бүгдээрээ өөрсдийн хөвгүүдийг хутагт хувилгаадаар тодруулж, нэр нөлөөг нь улс төрийн хэрэгт ашиглаж байсан бол, Сэцэн хан, түүний угсааны ноёд үр хүүхдээ хутагт хувилгаанаар тодруулаагүй нь байр сууриа бэхжүүлэхэд сөрөг нөлөө үзүүлсэн гэлтэй байна.

Ямар ч атугай, Шолойгоос хойшхи Сэцэн хангуудын эрх нөлөө түүний хэмжээнд огт хүрээгүйгээр барахгүй, аажмаар сулран доройтох хандлага илэрч эхэлсэн нь тодорхой ажээ. Үүнийг нөгөө талаар Түшээт ханы бүх Халхыг тэргүүлэн захирах үзэл санаа, үйл ажиллагааг Сэцэн хангууд дэмжиж, хувийн ашиг сонирхлоо хязгаарлаж байснаар тайлбарлах боломжтой.

Хэдийгээр Шолойн дараахь Сэцэн хангуудын үйл ажиллагаа түүнийг гүйцэхгүй, бусдын нөлөөнд их бага хэмжээгээр автах хандлага байсан боловч, Шолойг залгамжлан Сэцэн хан хэмээх цол зүүж, харьцангуй нэгдмэл байдлаа хэвээр хадгалсаар байсан явдал нь хожим Манжийн эрхшээлийн үед Сэцэн хан аймаг хэмээх бие даасан аймаг бий болох үндэс суурь нь болжээ. Манжийн эрхшээлд орох хүртэл Халхын хангуудын цол чимэг нэгэн мөр болж цэгцрээгүй байсан бол, ганцхан Сэцэн ханыхан л Сэцэн хан хэмээх цол чимгийг тууштай хэрэглэсээр байжээ.

1691 онд халхчууд Манжид дагаар орсноос хойш Сэцэн хан аймгийг байгуулж, Сэцэн ханыг үе улиран залгамжлуулахаар болов. Тус аймаг Халхын дорнод хэсэгт байрлаж, урьдын адил Дорнод Монголын бүс нутгийн хамгийн гол улс төрийн тоглогч болж байсан билээ. Ийнхүү тусгай аймаг байгуулагдахад анхны Сэцэн хан Шолойн үйл ажиллагаа, нэр хүнд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн нь дамжиггүй.

Сэцэн хан Шолой, түүний залгамжлагчдын захирсан аймаг нь XVII зуунаас хойш өнөөгийн Монгол улсын зүүн хэсэг төдийгүй, Өвөр Монголын зүүн хойт хэсэг, Хөлөнбуйрыг багтаасан Дорнод Монголын бүс нутгийн түүх, угсаа-соёлын хэв шинж бүрдэхэд ихээхэн нөлөө үзүүлснийг онцлон тэмдэглэх нь зүйтэй.

**Abstract:** In the early XVII century, a new political player called Setsen khan appeared in the eastern part of Khalkha, and had played an important role in internal politics and foreign relations of Khalkha. Especially, scope and initiative of political activities of the first Setsen khan was on another level than his successors, and left an indelible mark in political history of Khalkha. However, scopes of activities of the another Setsen khans, succeeded to the throne after Sholoi, had narrowed constantly. It can be explained by the following reasons. The main reason was the strengthening of power of Tusheet khan. For example, Tusheet khan Gombodorj had gradually strengthened his position by declaring his son Zanabazar as incarnation of Jibzundabma khutagt, and used him in politics successfully. Also, his son Tusheet khan Chakhundorj interfering in internal conflicts which erupted in the Right wing

of Khalkha in 1660s, became more powerful. Meanwhile, the authority of the Setsen khans had been weakened gradually. On other hand, the nobles headed by Tusheet khan and Jibzundamba khutagt had the right to enthrone Setsen khans by convening assembly. This gave the opportunity the Tusheet khan to become increasingly influential for Setsen khans. Moreover, remnant tribes of Southern Mongolia such as Avga, Khuuchid, Avganar who were under rule of Setsen khans submitted to Qing dynasty. It seems that it weakened the position of Setsen khans. While almost all of the another powerful nobles of Khalkha declaring their sons and grandsons as incarnations had used their influences in political life, only Setsen khan had never declared their sons as incarnations. It also played a negative role in strengthening Setsen khan's position. Taken as a whole, although political activities of the Setsen khans were not as good as Sholoi's activities, the maintaining its unity and succession of the title 'Setsen khan' became a basis to establish an independent aimag called Setsen khan aimag in the period of under Manchu Qing rule.